

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 9 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 9 дүгээр сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 795 болж, 2013 оны мөн үеэс 69 хүнээр өсч, өмнөх сарынхаас 248 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 50.57 хувь буюу 402 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 1810 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 1300 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 40.85 хувь буюу 531 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 9 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 584 ажилгүй иргэний 25,4 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 21,6 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 14,0 хувь нь мэдлэг чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 12,2 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 6,6

хувь нь өөр газраас шилжин ирсэн; 2,1 хувь нь гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 2,0 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1,4 хувь нь байгууллага татан буугдсан; 1,2 хувь нь цэргээс халагдсан; 0,5 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих; 0,5 хувь нь тэтгэвэрт гарсан; 0,5 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 0,4 хувь нь хорих газраас суллагдсан; 11,5 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр

2014 оны эхний 9 сард НДШ-ийн орлого 11.04 тэрбум ₮ болж төлөвлөгөө 90.63 хувь болж, төлөвлөгөөг 11 сум 1.16-9.85 хувиар биелүүлж, бусад сум 0.31-26.9 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого

461.9 сая ₮ болж төлөвлөгөөг 10 сум 0.71-13.36 хувиар биелүүлж, бусад сум 0.36-60.41 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 23.1 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.0 хувийг өндөр настны, 10.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 227160 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 38.84% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 27.84%; тэтгэмжийн даатгалын сангийн 92.77%; эрүүл мэндийн даатгалын сангийн 93.65%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 99.76%; ажилгүйдлийн даатгалын сангийн 92.88%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 9 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 49154 хүнд олгож, 7.6 тэрбум₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 10.34 хувь 5669 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 42.98 хувь 2.3 тэрбум₮-өөрөслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 105730 ₮болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.89 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 26.97 хувийг халамжийн тэтгэвэр; 10.61 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.63 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.38 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.27 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 1.13 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тусбүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 9 сард 11590 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.8 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 9 сард 1037 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 111 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 9 сард нялхсын эндэгдэл 14 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 5-аар өссөн байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд 1 хүүхэд гарсан ба өмнөх онд 1 хүүхэд буюу ижил байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар



2014 оны эхний 9 сард халдварт өвчнөөр 350 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 28.5 хувь буюу 140 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.5 дахин, заг хүйтэн 1.5 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 40 байгаа бол: Зуунмод 113, Сүмбэр 81, Мөнгөнморьт 61, Сэргэлэн 43 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Төв аймгийн 2014 оны 9-р сарын цаг агаарын байдлыг

Олон жилийн дундажтай харьцуулсан тойм 5-нд нутгийн баруун өмнөд хэсгээр 0,0-2,5 мм, 8-нд нутгийн зүүн өмнөд хэсгээр 0,0-2,2 мм, 9, 18-нд зарим газраар 0,0-1,9 мм, 6-ны шөнө 0,1-16,3 мм, өдөр 0,0-14,0 мм, 12, 21-нд ихэнх нутгаар 0,0-10,0 мм, 13-нд бүх нутгаар 0,3-25,0 мм бороо орлоо. Харин 28-нд ихэнх нутгаар 0,0-6,0 мм цас орж, өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр 1-11 см цасан бүрхүүл тогтсон боловч өдөртөө хайлсан байна. Сарын нийлбэр тунадас 1,3-50,8 мм. 1, 2-р арав

хоногийн эхэн, сүүлийн хагас, 3-р арав хоногийн эхэн эцсээр тунадасны зонхилох хувь орж, харьцангуй сэрүүвтэр байв.

1-5, 10-12, 16-20, 23, 26-нд дулаарч, өдөртөө 24-34 градус, ялангуяа 1-4-нд өдөртөө халж, ихэнх нутгаар 28-34 градус дулаан байлаа. Харин 6, 9, 13-14, 21-22, 25-нд харьцангуй сэрүүсч, 13-14, 21-22-нд хүйтэрч, хөрсөн дээр цочир хүйтэрч, 27-28-нд эрс хүйтэрч, шөнөдөө 4-13 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан байлаа.

Энэ сард 28-нд ихэнх нутгаар анхны нойтон цас орж, цасан шуурга шуурсан боловч аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн цаг агаарын муудалт болоогүй.

Олон жилийн дундажтай харьцуулсанд үнэлт

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2013 оны 9-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур нь бүх нутгаар ойролцоо буюу 1-Зорчим градусаар дулаан

-өдрийн хамгийн их температур нь ихэнх нутгаар 3-7 градусаар дулаан

-шөнийн хамгийн бага температур нь ойролцоо буюу ихэнх нутгаар 1-4 градусаар хүйтэн байв.

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд газар тариалангийн бүс нутгаар ахиу, нутгийн зүүн өмнөд хэсгээр бага хур тунадас орсон байна. Салхи шуурга багатай, ихэнх хугацаанд цаг агаар тогтвортой байлаа.

- Анхны цочир 9-р сарын 1-р арав эцсээр буюу хожуу ажиглагдлаа. Цочир хүйтрэлтээр 6, 8-9, 13-14, 21-нд сэрэмжлүүлэг мэдээ зарлагдсан, 28-нд орон шуурга, нойтон цасаар аюул агаар мэдээ ирсэн байна.

2014

ОНЫ АРАВДУГААР САРЫН ЦАГАГААР ЫНУРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хойд хэсгээр 0-5 градус хүйтэн, бусад нутгаар 0-5 градус дулаан буюу нийт нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Дулаарах үе Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан байна.

Бага зэрэг дулаарах үе Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр уулархаг нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан байна.

Эрс сэрүүсэх үе Хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагаст бага зэрэг хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна.

Хүйтрэх үе Гуравдугаар дунд үеэс хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 13-

18, өдөртөө 3-8 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна.

Бусад хугацаанд уулархаг нутгаар шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан байна.

Энэ сард Төв аймгийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, нутгийн баруун хойд хэсгээр дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе ба сүүлчээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар цас орно. Хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, сүүлчээр нь зарим газраар цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим газраар 12-14 м/с, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн өмнөд хагаст 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын сарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, Алтайн уулархаг нутаг, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор дунджаас дулаан, хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим буюу түүнээс бага, Баян-Өлгий, Увс, Завхан, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Дорнодын хойд, Хөвсгөлийн баруун, Өвөрхангай,

Сэлэнгийн зүүн, Төв, Хэнтийн ихэнх нутгаар дунджаас ахиу орохоор байна.

10 дугаар сарын эхээр ихэнх нутгаар дулаан, хур тунадас бага орохоор байгаа боловч сарын дунд үеэс зарим газраар цас орж, хүчтэй цасан ба шороон шуурга шуурахыг онцгой анхаарна уу.

2014 ОНЫ АРАВНЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Агаарын температурын олон жилийн дундаж нь уулархаг нутгаар 14-19, бусад нутгаар 8-13 градус хүйтэн бөгөөд ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нийт нутгаар олон жилийн дунджаас ахиу байна.

Гол мөрний усны түвшин ба урсацын Урьдчилсан мэдээ

10 дугаар сард агаарын температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим ба түүнээс дулаан байх хандлагатай байгаатай уялдан нийт нутгаар гол мөрний намрын мөсний үзэгдэлэхлэх хугацаа олон жилийн дунджийн орчим, харин битүү мөсөн бүрхүүл тогтох хугацаа 5-10 хоногоор өмнө ажиглагдах төлөвтэй байна. Ихэнх гол мөрөнд 10 дугаа сарын дунд үе ба 11 дүгээр сарын эхээр мөсний үзэгдэл ажиглагдаж эхлэх ба 11 дүгээр сарын 5-20-ны хооронд битүү мөсөн бүрхүүл тогтоно.

Прогнозоос харахад ихэнх гол мөрөнд битүү мөсөн бүрхүүл 11 дүгээр сарын дунд үед тогтох төлөвтэй байгаа хэдий ч энэ жил гол мөрөн, нуурын мөсний зузааны даац хүн, мал,

машин техник явахад аюулгүйн хэмжээнд хүрч чадахгүй гэдгийг анхаарч, мөс цөмрөх аюулаас болгоомжлохыг ард иргэдэд сануулж байна.

Зарим гол мөрний намрын мөсний үзэгдэл эхлэх, мөсөн бүрхүүл тогтох хугацааг хүснэгтэд үзүүлэв.

Аюулт үзэгдэл, осол 2014 оны эхний 9 сард 46 удаа гарсны улмаас 10 хүн амь насаа алдаж, 9 толгой мал хорогдлоо. Энэ оны 9 сард объектын түймэр 23 удаа, шатсан гэр, орон сууц 11 удаа бүртгэгдлээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2014 оны эхний 9 сард 655.1 сая ₮-ийн хохирол учирлаа.

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 9 сарын байдлаар*			
Үзүүлэлт	2013 IX	2014 IX	2014 IX / 2013 IX %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	42	46	109.5%
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	1	10	1000.0%
Шатсан гэр, орон сууцны тоо	11	11	100.0%
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтаны тоо	3	9	300.0%
Объектын түймрийн тоо	24	23	95.8%
Учирсан хохирлын хэмжээ, сая ₮	238.5	655.1	274.7%

Тайлбар: * - Онцгой байдлын газрын мэдээ




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 9 сард аймгийн хэмжээнд 706 гэмт хэрэг бүртгэгдэж 594 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2.0 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар



Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 9 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 40.4 хувь нь хулгай, 24.9 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 17.0 хувь нь замын осол, 3.3 хувь нь танхай дээрэм, 1.4 хувь нь хүн амины хэрэг, 13.0 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Аргалант, Баян, Лүн сумдад 10000 хүнд 305-124 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (80) харьцангуй их гарлаа.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 23 хэргээр өслөө.

Зуунмод суманд 33 эмэгтэй, 840 эрэгтэй нийт 873 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 126 хүнээр буурлаа

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар, тэр-бум төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 9 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 1289 гүйцэтгэх хуудсанд нийт 3.55 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 490 гүйцэтгэх хуудсанд ногдох 620.2 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 799 гүйцэтгэх хуудасны 2.93 тэрбум ₮-өөс 389 хуудасны 1.88 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 48.69 хувь, үнийн дүнгээр 63.99 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 9.9 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 44.79 нэгжээр тус тус өслөө.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 9 сард кассын орлого 502.5 тэрбум₮, кассын зарлага 501.4 тэрбум₮ болж, гүйлгээнд 86.2 тэрбум₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад **жигжиг худалдаа, үйлдвэрлэлийг** дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон

зээлийн үлдэгдэл 9 сарын 30-ний байдлаар **118.6** тэрбум₮, байгаа нь өмнөх оны эцсээс **26.3** тэрбум₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт **27.6** тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 9 сарын 30-ний байдлаар 36.8 тэрбум₮ байна.Харилцах дансны үлдэгдэл 9 сарын30-ны байдлаар 261368 иргэний 10.7 тэрбум₮ боллоо.


ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү1.19-1.34 хувь, хугацаатай доод хүү 0.62-0.65 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0.60-0.62 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийнорлого 2014 оны эхний 9 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 8.4 тэрбум, зарлага 45.1 тэрбум болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 123.89 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Бууны албан татвар, газрын төлбөр, бусад төлбөр хураамж, төсөвт газрын өөрийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 21.4 хувь буюу 1.5 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 83.86 хувийг татварын, 15.65 хувийг татварын бус, 0.49 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь2013 оны



мөн үеэс татварын орлого 1.70 нэгжээр өсч, татварын бус орлого 1.51 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.19 нэгжээртус бүр буурлаа.Аймгийн нийт 3 шатны орлого 11.1 тэрбум ₮ болж аймгийнх 6.9 тэрбум ₮ буюу 61.80 хувь, сумынх 1.5 тэрбум ₮ буюу13.53 хувь, улсынх 2.7 тэрбум ₮ буюу 24.68 хувийг тус бүр бүрдүүлжээ.2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 32.26 хувь буюу 143.3 сая ₮-өөрөсч 587.3 сая ₮, авлага 81.97 хувь буюу 79.7 сая₮-өөрөсч 176.8

сая₮боллоо.Ороннутгийнтөсвийнорлого8.1тэрбум₮болж, төлөвлөгөө 127.61хувиарбиелэгдэж.

Сумандтөвлөрүүлэхтөсвийнорлого 1.5 тэрбум ₮болж, төлөвлөгөө237.32 хувьбиелж, Эрдэнэсант, Алтанбулаг сум 6.8-10.1 хувиар тасалдууллаа.

Аймагттөвлөрүүлэхтөсвийнорлогынтөлөвлөгөө6.9 тэрбум ₮болж112.16 хувьбиелж, Баянжаргалан, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Цээл, Өндөрширээт, Баянхангай, Угтаал, Мөнгөнморьт, Эрдэнэсант, Батсүмбэр, Бүрэн, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Лүнсүмд 40.32-0.90 хувиартасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ


2014оны9 дүгээр сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үеболох 2010 оны 12 дугаар сараас

49,05%, өмнөх оны мөн үеэс 11,98%, өмнөх сараас 1,61 хувиар тус тус өсөв.

Аймгийн төвийн хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 11,98 хувь өссөний дотор зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 16,99%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 16,18%; хувцас бөс бараа гутлын бүлэг 15,24%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 14,73%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 13,74%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 13,18%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 11,61%; тээврийн бүлэг 9,26%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 8,53%; боловсролын үйлчилгээний бүлэг 7,59%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 6,64%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 8,66%-аар буурав.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 9 дүгээр сарын 1,61 хувиар өссөн өсөлтийн 0,53 нэгж /33,04%/ нь тээврийн бүлгийн, 0,52 нэгж /32,33%/ нь хувцас, бөс бараа,

гутлын бүлгийн 0,34 нэгж /21,15%/ нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийнх байв.

Зураг II. 5

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 9-р сард	
	пунктээр	хувиар
Бүгд	1.61	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.04	2.80%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.26%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.52	32.33%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.08	4.86%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.34	21.15%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.05	3.22%
07. ТЭЭВЭР	0.53	33.04%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	-0.06	-3.93%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	1.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.08	5.27%



Хөдөө аж ахуй

10 сарын 1-ний байдлаар үр тариа 81039.7 тонн, төмс 53697.6 тонн, хүнсний ногоо 7571.3 тонн хурааж авлаа. Урьд оны мөн үеэс үр тариа 43603 тонноор өсч, хүнсний ногоо 332.6 тонн, төмс 4472 тонноор тус бүр буурлаа.

	2014-09	2013-09	2012-09	2011-09	2010-09
Үр тариа (тонн)	81039.7	37436.5	22843.2	81748.4	56485.2
Үүнээс улаан буудай(тонн)	71417.1	34194.5	22792.9	78337.9	55239.2
Төмс (тонн)	53697.6	58169.6	88793.7	62663.3	39829.6
Хүнсний ногоо (тонн)	7571.3	7903.9	8304.3	11820.6	11325.4
Бэлтгэсэн өвс- бүгд (тонн)	78840.9	59201.9	94471.5	71067.0	66503.8
үүнээс - улсын фондод		136.7	391.8	568.0	589.0
Бэлтгэсэн гар тэжээл (тонн)	3108.9	1182.8	4963.1	7426.9	815.3
Ногоон тэжээл, олон наст өв	8289.0	8264.0	5038.0	2975.4	7229.0
Бэлтгэсэн дарш (тонн)	2935.0	2345.0	138.0	1615.0	18.0
Тосны ургамал (тонн)	4144.2	2171.8	1819.2	674.9	380.0
Чихрийн манжин (тонн)					
Бэлдсэн уринш (гектар)	67509.0	58894.0	3721.0	69777.0	32201.0

Төл бойжилт

10 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 89.62 хувь 1435.86 мянган хээлтэгч мал төллөж, 1447.27 мянган төл гарсны 98.9 хувь 1430.76 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 11.2 хувь буюу 160.27 мянгаар;

бойжиж буй төл 12.5 хувь 179.04 мянгаар тус бүр өслөө.



Гарсан төлийн 1.1 хувь болох 16503 толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 73.09 хувь буюу 12063 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 0.8, унаганы 1.6, тугалын 1.4, хурганы 0.8, ишигний 1.5 хувь нь тус бүр хорогдов. Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэсант, Баянцогт, Сүмбэр сумд гарсан төлийнхөө 3.80-2.85 хувь буюу 4889-459 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 49.8 хувийг (бүгд 8205 төл) эзлэв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	Мян.тол				
	2010	2011	2012	2013	2014
Бүгд	729.8	1137.5	1164.5	1251.7	1430.8
Ботго	0.3	0.4	0.6	0.5	0.5
Унага	28.8	47.9	51.3	58.0	70.7
Тугал	39.7	54.1	59.0	66.4	80.7
Хурга	403.2	607.5	615.4	677.2	767.0
Ишиг	257.8	427.6	438.3	449.6	511.9

Том малын зүй бус хорогдол

2014 оны 10 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.4 хувь буюу 15799 том мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 1.07 дахин буюу 16969 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянчандмань, Батсүмбэр, Сүмбэр, Мөнгөнморьт,


Баянцогт сумд оны эхний малынхаа 1.7-0.9 хувь буюу 918-528 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 23.18 хувь (бүгд 3663) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо эхний 9 сард төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	515027	31693	15339	32768	15799
Тэмээ	72	3	7	23	12
Адуу	25039	1639	1160	1770	1336
Үхэр	25146	1471	1444	1993	1431
Хонь	225228	11842	6415	14215	6826
Ямаа	239542	16738	6313	14767	6194

Оны эхний тэмээний 0.4; адууны 0.5; үхрийн 0.6; хонины 0.4; ямааны 0.5 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 38.70 хувь нь өвчнөөр, 25.78 хувь нь хээлтэгч мал эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, эхний 9 сард



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 9 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 14.35 тэрбум₮-ийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 1.09 дахин буюу 7.48 тэрбум₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Баянчандмань, Баянцагаан, Зуунмод, Жаргалант, Баянцогт, Алтанбулаг, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Баян сумд38.23-0.63 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 96.36) хувийг эзлэв.

Зураг II.6Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 IX	2014 IX	2013 I-IX	2014 I-IX	Дүнд эзлэх % Percentage share to total	
					2013-I-IX	2014-I-IX
Нийт дүн	1,350.71	4,121.94	6,863.65	14,352.33	100.0	100
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	499.51	2,894.31	1,172.59	8,037.53	17.08%	56.0
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	802.18	1,184.69	4,369.71	5,282.38	63.66	36.8
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	49.02	42.94	1,321.35	1,032.42	19.3	7.1

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ундаа үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 8.6 дахинаас-12.2 хувь буюу 6.86 тэрбум-2.9 сая₮-өөр өссөн нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 9 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 7.19, боловсруулах үйлдвэрлэл 36.81, уул уурхайн үйлдвэрлэл 56.00 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, хувиар



II.6 Барилга


Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 9 сард 10183.8 сая₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 195.51 хувь буюу 6737.7 сая₮-өөр өсөв.

Барилга угсралт их засварын ажлын 12.89 хувь нь орон сууцны барилгад; 25.59 хувь нь орон сууцны бус барилгад; 61.52 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Энэ нь 2013 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 26.5 пунктээр буурч; орон сууцны


барилгын ажил 2.02 пунктээр; инженерийн барилга байгууламжийн ажил 24.48 пунктээр тус тус өссөн үзүүлэлт юм.

Барилгын албарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 12 хүнээр өсч, цалингийн сан 235,7 сая₮-өөр өсөв.

Зураг II.8



Барилгынажлынгүйцэтгэл, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр



II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 9 сард 202.2 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 103.9 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 0,8 хувь 20.3 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 72.9 сая ₮ болж, нийт орлогын 73.8 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 26.12 хувийг албан бичгийн, 7.5 хувийг зорчигчдийн, 66.38 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр